



“ДУЛААН ШАРЫН ГОЛ” ТӨХК-ИЙН
ЗАХИРАЛ Б.ЭНХЦЭЦЭГ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.03.15 № 3/433
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Дулаан Шарын гол” ТӨХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээний, өмчийн өөрчлөлтийн тайлан болон холбогдох тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

“Дулаан Шарын гол” ТӨХК-ийн удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг хариуцлага хүлээнэ.

“Дулаан Шарын гол” ТӨХК-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан нь үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Дулаан Шарын гол” ТӨХК-ийн санхүүгийн тайлан, түүний тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлт, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан болно.

Тайлбар:

1. Борлуулалтын авлага 78,872.2 мянган төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй тайлагнасан.

2. Дээд шүүхийн ХШИХ-ийн 2017 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 001/2017/00072 дугаар тогтоолоор ДСЦЭС ХК-д төлөхөөр тогтоогдсон 200,000.0 мянган төгрөгийн өр төлбөрийг шүүхийн шийдвэрийг үндэслэн Тайлагналын дараа үеийн үйл явдал НББОУС 10.8-ын дагуу залруулан бүртгээгүй.
3. Үндсэн баримт, санхүүгийн бүртгэлээр нотлогдохгүй байгаа 6 байгууллагын 17,502.9 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй тайлагнасан.
4. К4-р зууханд их засвар хийхдээ элэгдлийн норм хугацаа дуусаагүй, дансанд бүртгэлтэй өөр зуухнаас 4,085.0 мянган төгрөгийн сэлбэгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлгүйгээр зарцуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Дээрх алдаа зөрчлийг эс тооцвол "Дулаан Шарын гол" ТӨХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулгуудыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлж Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



“ДУЛААН ШАРЫН ГОЛ” ТӨХК 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

САГ-ын Тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663
Цахим хаяг:

Аудитын менежер: Я.Самбууням
Утас: 260512
Цахим хаяг:

Аудитор: Н.Золзаяа
Утас: 261885
Цахим хаяг:

ТАБ-ын хаяг: Үндэсний аудитын
газар

Байршил: Чингэлтэй дүүрэг

Цахим хуудас: www.audit.mn

2017 оны 3 дугаар сар 10

Аудитын тайлан

Хавсралт 1: Дуусвар тайлан

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: МЗ-ийн хариу

Хавсралт 5: Аудит хийсэн санхүү, төсвийн
гүйцэтгэлийн тайлан, тодруулга

Хавсралт 6: Асуудлын бүртгэл

Хавсралт 7: Үйлчлүүлэгчийн албан бичиг,
санхүүгийн тайлан, тодруулга

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Материаллаг байдал
6. Дотоод хяналт
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Шилэн дансны мэдээлэл
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Тайлбар захидал
18. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.8, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.5 дугаар зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “Дулаан Шарын Гол” ТӨХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /САГ-2017/65/СТА-ТӨҮГ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Дулаан Шарын Гол” ТӨХК-ийн 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /НББОУС/, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/ түүнд нийцүүлэн гаргасан аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Компанийн удирдлага санхүүгийн тайлангаа НББОУС, СТОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“Дулаан Шарын Гол” ТӨХК-ийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 2 дүгээр сарын 15-наас 2017 оны 3 дугаар сарын 10-ны хооронд хийхээр төлөвлөн “Ди Эй Би Жи Аудит” ХХК-ийн аудитор Н.Дэлгэрмаа хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

“Дулаан Шарын Гол” ТӨХК-ийн 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 2 дүгээр сарын 13-нд “Ди Эй Би Жи Аудит” ХХК-д ирүүлсэн.

“Ди Эй Би Жи Аудит” ХХК аудитыг 2017 оны 2 дүгээр сарын 13-наас 2017 оны 3 дугаар сарын 07-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 3 дугаар сарын 15-нд ЭХЯ-ны харъяа “Дулаан шарын гол” ТӨХК-д хүргүүлнэ.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

“Дулаан Шарын Гол” ТӨХК-ийн удирдлага нь Монгол улсын “Компанийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Эрчим хүчний тухай”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай”, холбогдох албан татварын хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль НББийн тухай хууль нь шинэчлэгдэн 2016 оны 1 дүгээр сарын 1-нээс мөрдөн ажиллаж байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

“Дулаан Шарын Гол” ТӨХК-ийн гол зорилго нь “Хэрэглэгчдийг стандартын шаардлагад нийцсэн дулааны эрчим хүч, ундны цэвэр усаар тасралтгүй найдвартай хангаж, бохир усыг ариутган татан зайлуулах ба эдийн засгийн үр ашигтай ажиллаж, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг өсгөж, тэдний ашиг сонирхлыг хангаж ажиллах”-д оршино. Үйл ажиллагааны зорилтоо биелүүлэхэд дараах дараах хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

1. Монгол Улсын Компанийн тухай хуулийн 2.4-д “Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанид төрийн болон орон нутгийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журмыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар, төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгох, гүйцэтгэх удирдлагыг томилох, төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороо, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга болон тэдгээрийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна”,
2. Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16.1-д “Өөрт олгогдсон үл хөдлөх хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах;”,
16.2-т “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар үндсэн хөрөнгийг зөвхөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлтэйгээр данснаас хасах буюу борлуулах, устгах эрхтэй.”
18.1-д “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын Захирал удирдана. Захирлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, зохих салбар, хүрээний яамтай зөвшилцөн томилох буюу өөрчилнө”.
21.1-д “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага жил бүрийн 3 дугаар сарын 01-ний дотор тухайн хуулийн этгээдийн зорилт, түүнийг хэрэгжүүлэх талаарх санал /цаашид “зорилтын санал” гэх/-ын төслийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ”.
21.4.2-т “Төрийн өмчийн төлөөлөгч төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах талаар санал боловсруулж төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад оруулах”;
3. Монгол улсын Төсвийн тухай хуулийн 8.9.8. “Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх”.

“Дулаан Шарын Гол” ТӨХК-ийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар “Дулаан Шарын Гол” ТӨХК-ийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс үйлчлүүлэгчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд нягтлан бодох бүртгэлийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 38-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад НББ-ийн бодлогын баримт бичгийг 2014 онд Нягтлан бодох бүртгэл хөгжүүлэх сангаар боловсруулан санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж байна. Нягтлан бодох бүртгэлийг “Даймонд” санхүүгийн програмаар хөтөлж, аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Компьютерийн системийн үйл ажиллагааны нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Материаллаг байдал:

Эрчим хүчний салбарын үнэ тарифыг тогтооход эрчим хүчний компаниудын өөрийн бүрэн өртгийг суурь болгон тооцдог учир Материаллаг байдлын түвшинг төлөвлөлтийн шатанд батлагдсан төлөвлөгөөний нийт зардлын 0.2 хувиар 5,007.8 мянган төгрөгөөр тогтоосон. Гүйцэтгэлийн шатанд нийт зардлын гүйцэтгэлийг материаллагийн түвшинг тогтоох суурь болгон сонгож, 0.2 хувиар тооцон материаллагийн түвшинг 5,062.8 мянган төгрөг гэж тогтоосон. /ТАБ-СТА-В-1/

/мян.төг/

Данс	Материаллаг байдал	
	Төлөвлөлтийн шатанд	Жилийн эцсийн аудитад
Нийт зардал	5,007.8	5,062.8

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг нь үнэлсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед ҮР НӨЛӨӨГҮЙ гэж тооцсон ба дахин хянахад бүртгэлээр тавих дотоод хяналтын үйл ажиллагаа ДУНД байна. /ТАБ-СТА-А-1/

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг 2016 онд үндсэн үйл ажиллагаанаас 1,837,691.9 мянган төгрөг, туслах үйл ажиллагаанаас 70,552, мянган төгрөг нийт 1,908,244.7 мянган төгрөгийн орлоготой, 2,503,901.2 мянган төгрөгийн зардалтай, 595,656.5 мянган төгрөгийн алдагдалтай ажиллахаар баталсан. Тарифын зөрүүнд төсвийн санхүүжилтээр 500,000.0 мянган төгрөгийг олгож нийт алдагдал 95,656.5 мянган төгрөг байхаар төлөвлөсөн байна.

Байгууллагын удирдлагууд батлагдсан төлөвлөгөөний сар, улирлын хуваарийн дагуу гүйцэтгэлийг тайлагнаж, улирал тутамд ТУЗ, аудитын хороо, дотоод аудитор байгууллагын үйл ажиллагааны үндсэн зорилт, санхүүгийн үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

2016 онд Үндсэн үйл ажиллагааны орлого 1,971,393.3 мянган төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлого 37,411.5 мянган төгрөг, туслах аж ахуйгаас 18,803.0 мянган төгрөгийн орлого олж, тарифын зөрүүнд улсын төсвөөс 500,000.0 мянган төгрөгийг санхүүжилттэй нийт 2,527,607.8 мянган төгрөгийн орлоготой, 2,531,412.4 мянган төгрөгийн зардал гаргаж 3,804.6 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хууль 2014 оны 7 дугаар сарын 1-ны өдөр батлагдаж, 2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна. Энэ хуулийн зорилт нь улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагааг ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих, мэдээллийн тогтолцоог бүрдүүлэхэд оршино.

Тус байгууллага нь байгууллагын вэбсайт дээрх шилэн дансаа нээж нийт 6 хавсралтаар мэдээлэл байршуулах үүргийг бүрэн гүйцэтгэсэн байна.

1. Концессийн мэдээлэл хэсэгт томоохон худалдан авалт хийгдээгүй тул тавих мэдээлэл байхгүй байна
2. Нийтийн албанд нийгмийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хавсралтад үнэлгээний хорооны гишүүдийн “Ашиг сонирхлын зөрчилгүйн мэдэгдэл”-ийг байршуулсан.
3. Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээ тендерийн ерөнхий мэдээлэл хавсралтад тендерийн зарлагдаагүй тул байршуулах мэдээлэл байхгүй. Худалдан авалтын харьцуулалтын аргын мэдээллийг байршуулсан.
4. Бонд зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр хэсэгт 2016 онд гарсан хөрөнгө, мөнгөн дүнгээр гарсан захирлын тушаалуудыг байршуулсан.
5. 2016 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг байршуулсан.
6. 2016 оны Худалдан авах ажиллагааны тайланг байршуулсан байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 19 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 38 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Тогтоосон эрсдлүүдээс дараах эрсдлүүдийг гол гэж үзэн нарийвчлан шалгасан:

- Авлага, өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, эсвэл зөрүүтэй баталгаажуулсан байх. Авлагыг насжилтаар ангилан бүртгээгүйгээс найдваргүй өр авлага үүссэн байх, үүссэн тухайн үеийн баримт материал байхгүй байх
- Хөрөнгө бэлтгэх, данснаас хасах үйл ажиллагаандаа хууль, дүрэм, журам зөрчсөн байх

- Батлагдсан төсвийг хэтрүүлэн зардал гаргасан, зөвшөөрөлгүй зориулалт бусаар зарцуулсан байх

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Тайлант онд тус байгууллагын хувьд дараах материаллаг хэмжээний ажил гүйлгээ гарсан байна.

Нийт 201,680.7 мянган төгрөгийн авлага тайлагнаснаас 47.9 хувь буюу 96,715.0 мянган төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан. Борлуулалтаас үүссэн авлагын дүнд айл өрхүүдийн 69,645.1 мянган төгрөг, албан байгууллагын 9,227.1 мянган төгрөг нийт 78,872.2 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй тайлагнасан. Бусад авлагаар тайлагнасан 2 харилцагчийн 12,137.7 мянган төгрөгийн авлага тайлант жилийн төгсгөлд шүүхийн ажиллагаа явагдаж байсан бөгөөд балансын дараа аудит хийгдэх хугацаанд "АНУ Капитал" ХХК-ийн авлага 7,400.7 мянган төгрөгийг Дархан-уул аймгийн ИХАШ-ны шүүхийн 2017.02.03-ны өдрийн 177-р шийдвэрээр төлбөрийн чадваргүйн улмаас хэрэгсэхгүй болсон байна.

Өр төлбөрийн дансуудад нийт 720,613.1 мянган төгрөгийн өглөг тайлагнасан боловч нь 2 байгууллагын тулган баталгаажуулалтаар 742,054.3 мянган төгрөгийг дутуу, зөрүүтэй тайлагнасан. Мөн 3-аас дээш жилийн насжилттай, үндсэн баримт санхүүгийн бүртгэлээр нотлогдохгүй байгаа 6 байгууллагын 17,502.9 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй тайлагнасан байна.

Их засвар, хөрөнгө оруулалтын ажлыг ТУЗ-ийн 2016 оны 10-р сарын 28-ны өдрийн 05 тоот тогтоолоор 155,773.9 мянган төгрөг болгон тодотгосон. Гүйцэтгэлээр 155,569.1 мянган төгрөгийн худалдан авалт хийгдсэн.

Нийт 2,511,962.5 мянган төгрөгийн зардалтай ажилласнаас 974,910.9 мянган төгрөгийг цалин нийгмийн даатгалын шимтгэлд, 330,212.6 мянган төгрөгийн цахилгаан эрчим хүчний зардалд, ТУЗ-ийн зардалд 35,259.4 мянган төгрөг, Гүйцэтгэх удирдлагын зардалд 54,954.9 мянган төгрөгийг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулсан. Батлагдсан төлөвлөгөөнөөс цалин, нийгмийн даатгалын зардлыг 25,056.7 мянган төгрөгөөр хэмнэж, урсгал засварын зардлыг 6,629.5 мянган төгрөг, нүүрсний зардал 20,096.9 мянган төгрөг, бусад зардал 11,037.3 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан.

Энэ нь санхүүгийн тайлангийн тухайн дансуудад оршин байх, эрх ба үүрэг, үнэлгээ гэсэн батламж мэдэгдлийг бүрэн хангаагүй байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Тус байгууллагын 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний худалдан авалтын төлөвлөгөө гүйцэтгэлийг зэрэгцүүлж, хөрөнгийн дансдад авсан орлогын бүртгэлийг хөөж шалгах, шилэн дансны тайлан, өөрийн үйл ажиллагааны орлого, нийт зардлын батлагдсан төсөв гүйцэтгэлийг зэрэгцүүлэн хэмнэлт хэтрэлтийг хянах, цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, авлага, өглөгийн тооцооны дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 96.9 хувь, нийт зардлын 45.9 хувь, нийт хөрөнгийн 50.9 хувийг тус тус эзэлж байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Борлуулалтын авлагын бүртгэл:

Борлуулалтаас үүссэн авлагын дүнд айл өрхүүдийн 69,645.1 мянган төгрөг, албан байгууллагын 9,227.1 мянган төгрөг нийт 78,872.2 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй тайлагнасан нь НББ-ийн тухай хуулийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэснийг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй авлагын бодитой төлөгдөх болон нийт авлагаас найдваргүй болох магадлалтай дүнг гаргаж, Удирдлага, дотоод хяналтын зүгээс холбогдох хуулиудын дагуу хэрэг хөөн хэлэлцэх хугацаа зэргийг харгалзан хууль хяналтын байгууллагад шилжүүлэх нэхэмжлэлүүдийг цаг алдалгүй шийдвэрлэж байх талаар зөвлөмж өгснийг хүлээн зөвшөөрсөн .

2. Бусад авлагын бүртгэл:

2 харилцагчийн 12,137.7 мянган төгрөгийн авлага тайлант жилийн төгсгөлд шүүхийн ажиллагаа явагдаж байсан бөгөөд балансын дараа аудит хийгдэх хугацаанд "АНУ Капитал" ХХК-ийн авлага 7,400.7 мянган төгрөгийг Дархан-уул аймгийн ИХАШ-ны шүүхийн 2017.02.03-ны өдрийн 177-р шийдвэрээр төлбөрийн чадваргүйн улмаас хэрэгсэхгүй болсон байна.

Шийдвэрлэсэн нь: Тайлагналын дараа үеийн үйл явдал НББОУС 10.8-ын дагуу шүүхийн шийдвэрийг үндэслэн 7,400.7 мянган төгрөгийн авлагыг, Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт НББОУС 8.36.а-ын дагуу авлага бууруулан, алдагдлаар хүлээн зөвшөөрч, залруулан бүртгэх зөвлөмж өгсөн. Найдваргүй болсон авлагыг ХЭ-ийн хурлаар хэлэлцүүлж шийдвэр гарсны дараа залруулан бүртгэхээр хариу ирүүлснийг хүлээн авсан.

3. Өр төлбөрийн бүртгэл:

Аудитын тулган баталгаажуулах захидлаар Дансны өглөг дансанд Шарын гол ХК-ийн үлдэгдэл 542,054.3 мянган төгрөг, Дансны өглөг-Ашиглалтын зардал дансанд ДСЦТС ХК-ийн үлдэгдэл 200,000.0 мянган төгрөг нийт 742,054.3 мянган төгрөгийг санхүүгийн тайланд дутуу, зөрүүтэй тайлагнасан нь батлагдсан. Дархан-уул

аймгийн анхан шатны шүүхийн 2016 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн 644, 2016 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 1124-р шийдвэрүүд нь харилцагч 2 байгууллагын талд гарсан байна. Дээд шүүхийн ХШИХ-ийн 2017 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 001/2017/00072-р тогтоол нь ДСЦЭС ХК-ийн анхан шатны шүүхийн шийдвэр зөв болохыг баталж, Дулаан шарын гол ТӨХК нь 200,000.0 мянган төгрөгийг нэмж төлөхөөр тогтоосны дагуу залруулан бүртгээгүй нь НББ-ийн тухай хуулийн 20.2.6. "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"; 5.1.4. Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: "үнэн зөв байх" гэснийг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тайлагналын дараа үеийн үйл явдал НББОУС 10.8-ын дагуу шүүхийн шийдвэрийг үндэслэн Нягтлан бодох бүртгэлийн алдаа НББОУС 8.42-ын дагуу ДСЦТС ХК-ийн өглөгийг тайлант онд залруулан тайлагнах, Шарын гол ХК-ийн өр төлбөрийг шүүхийн шийдвэр гарсны дараа залруулахаар хойшлуулах талаар зөвлөмж өгснийг хүлээн аваагүй нь санхүүгийн үйл ажиллагаанд НББОУС-ыг дагаж мөрдөөгүй байна.

4. Өр төлбөрийн бүртгэл:

Дансны өглөг дансанд 3-аас дээш жилийн насжилттай, үндсэн баримт санхүүгийн бүртгэлээр нотлогдохгүй байгаа 6 байгууллагын 17,502.9 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй тайлагнасан нь НББ-ийн тухай хуулийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", 11.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн баримт болон санхүүгийн тайланг Архивын тухай хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол 10-аас доошгүй жил хадгална" гэснийг хэрэгжүүлээгүй байна

Шийдвэрлэсэн нь: Олон жилийн насжилттай 6 байгууллагын 17,502.9 мянган төгрөгийн өр төлбөрийн тооцоо нь санхүүгийн баримт, нягтлан бодох бүртгэлээр нотлогдохгүй байгаа тул өмнөх ажилтнуудаас лавлагаа авах, дотоод хяналт, өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт гаргуулж, шийдвэрлүүлэх талаар зөвлөмж өгсөн.

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Хөрөнгийн ашиглалт:

4-р зууханд их засвар хийхдээ хуучин зуухнаас 4,085.0 мянган төгрөгийн сэлбэгийг ямар нэг тогтоол шийдвэргүй зарцуулсан нь ТБОНӨ-ийн тухай хуулийн 16.2. "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар үндсэн хөрөнгийг зөвхөн төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлтэйгээр данснаас хасах буюу борлуулах, устгах эрхтэй" гэснийг хэрэгжүүлээгүй

Шийдвэрлэсэн нь: ТБОНӨ-ийн тухай хуулийн 31.3.1-д "худалдах, шилжүүлэх, устгах эд хөрөнгийн талаар өмч хамгаалах Байнгын зөвлөл дүгнэлт гаргасан байх" гэснийг хэрэгжүүлэх, холбогдох байгууллагаас зөвшөөрөл авч хасах зөвлөмж өгснийг хүлээж аваагүй.

2. Төрийн өмчийн бүртгэл:

Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг данснаас төрийн өмчийн дансанд ХЭ-ийн хурлын 2016 оны 07 тогтоолын дагуу 491,377.5 мянган төгрөгийг шилжүүлэн бүртгэсэн байна. Дээрх бүртгэл нь тогтоолын хавсралтын дүнтэй 1.0 сая төгрөгийн зөрүүтэй. Мөн хурлын тогтоолоор УБЕГ, СЗХ, МХБ-д бүртгүүлэн зохих зөвшөөрөл шийдвэрүүд гараагүй байхад бүртгэсэн нь Компанийн тухай хуулийн 17.4-д "Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг тухайн шийдвэр гарснаас хойш ажлын 10 өдрийн дотор хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлнэ" гэснийг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ХЭ-ийн хурлын өмнөх шийдвэрт баримтад тооцооллын алдаа гарсан тул дараагийн хурлаар хэлэлцүүлэн бүртгүүлэх үйл ажиллагааг хууль тогтоомжинд дагуу гүйцэтгэх талаар зөвлөмжийг хүлээн зөвшөөрсөн хариу ирүүлсэн.

3. Төлөвлөгөөт зорилт:

Батлагдсан төлөвлөгөөнөөс цалин, нийгмийн даатгалын зардлыг 25,056.7 мянган төгрөгөөр хэмнэж, урсгал засварын зардлыг 6,629.5 мянган төгрөг, нүүрсний зардал 20,096.9 мянган төгрөг, бусад зардал 11,037.3 мянган төгрөгөөр хэтрүүлсэн нь материаллаг байдлыг агуулж байна. Зардлыг батлагдсан төлөвлөгөөнөөс нийт дүнгээр 8,061.2 мянган төгрөгөөр хэтрүүлсэн нь ТБОНӨ-ийн тухай хуулийн 20.3-д "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэснийг хэрэгжүүлээгүй

Шийдвэрлэсэн нь: ШГХК-нь 2016 оны 10-р сараас халаалт нэмж авсантай холбоотойгоор 140,341.8 мянган төгрөгийн орлого орж, түүнтэй холбоотой нүүрсний зардал, цахилгааны зардал болон засварын зардал гарсан. Бусад зардалд НӨАТ-ын алданги 8,861.6 мянган төгрөг, шүүхээр тогтоогдсон найдваргүй авлагыг ХЭ-ийн хурлаар хэлэлцүүлэн 2,227.7 мянган төгрөгийг алдагдал болгон шийдвэрлэсэн дүн нөлөөлсөн талаар тайлбарыг ирүүлсэн.

4.Хөрөнгийн тооллого:

Санхүүгийн тайлангаар 3,252,596.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 121,981.6 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгө тайлагнасан. Жилийн эцсийн үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тооллого хийх тухай захирлын 2016 оны А/35 тушаал гарч тооллогын комиссын бүрэлдэхүүн, тооллого хийх хуваарийг баталсан байна. Аудитын багт тооллогын бүртгэл, тооллогын үр дүнг нэгтгэсэн бүртгэл, тайланг ирүүлээгүй нь НББ-ийн тухай хуулийн 12.1. "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх

удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2. "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" гэснийг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ТБОНӨ-ийн тухай хуулийн 72, 73-р зүйлүүдийг мөрдөн тооллогыг явуулж үр дүнг тодорхойлж хэвших. Хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад дотоод хяналт, өмч хамгаалах байнгын зөвлөл, захирлын тушаал шийдвэрүүдийг болон аудит, хяналтын байгууллагуудын зөвлөмжийг цаг алдалгүй хэрэгжүүлж байх талаар зөвлөмж өгснийг хүлээн авсан.

5. Худалдан авалт:

Батлагдсан төлөвлөгөөний дагуу нийт 293,566.6 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн. Үүнээс бусад сэлбэг 834.0 мянган төгрөг, тавилга эд хогшил 2,644.0 мянган төгрөг, компьютер дагалдах хэрэгсэл 5,818.7 мянган төгрөг нийт 9,296.7 мянган төгрөгийн худалдан авалт нь батлагдсан төсвийг хэтрүүлсэн нь ТБОНӨ-ийн тухай хуулийн 11.3 "төрийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалтыг холбогдох байгууллагатай тохиролцон тогтоох"; 14.2.1 "өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах" гэснийг хэрэгжүүлээгүй байна

Шийдвэрлэсэн нь: Их засвар, ХО, ТЗБАХ-ээр хийгдэх ажлыг ТУЗ-ийн 2016 оны 10-р сарын 28-ны өдрийн 05- тоот тогтоолоор 155,773.9 мянган төгрөг болгон тодотгосон дүн дотор захирлын өрөөний засвар, тавилга, компьютерыг нийт дүнгээр оруулсан баримтыг ирүүлсэн.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

ДСЦТС ХК-д төлөх өглөгийн үлдэгдлийн зөрүү 200,000.0 мянган төгрөгийг төлөх нь зөв гэсэн дээд шатны шүүхийн шийдвэр 2017.01.24-ний өдөр гарсан нь "Тайлагналын дараа үеийн үйл явдал" НББОУС 10.8-д "Аж ахуйн нэгж нь тайлагналын өдрийн дараах залруулагдах үйл явдлыг тусгахын тулд санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөгдсөн дүнгүүдэд залруулга хийх шаардлагатай болдог" гэсний дагуу залруулах зөвлөмж өгснийг үйлчлүүлэгчийн удирдлага хүлээж аваагүй, тайланд залруулаагүй болно.

Тайлагналын өдрийн дараах залруулагдах үйл явдалд НББОУС 10.9.а-д "тайлагналын өдрийн дараах шүүхийн тогтоол, шийдвэр нь тайлагналын эцсийн өдөр аж ахуйн нэгж үүрэг хариуцлагыг хүлээж байсан гэдгийг бататгадаг".

НББОУС 10.3-д "Тайлагналын өдрийн дараах үйл явдал гэдэг нь санхүүгийн тайлан гаргасан өдөр ба түүнийг хэвлэн нийтлэхийг хүлээн зөвшөөрсөн өдрийн хооронд үүссэн зохистой ба зохисгүй үйл явдал юм"

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Эрчим хүчний зохицуулах хорооны 2014 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 228 дугаар тогтоолоор тус компанийн "Шарын гол" ХК-иас худалдан авах 1 тн нүүрсний үнийг 30,000 /гучин мянган/ төгрөгөөс дээшгүй байхаар тогтоосон. "Дулаан Шарын Гол" ТӨХК нь дээрх тогтоолыг хэрэгжүүлэн данс бүртгэлдээ

Шарын гол ХК-д өгөх өрийн дансны үлдэгдлийг 73,502.4 мянган төгрөгөөр тайлагнасан байна. Дээрх өрийг тулган баталгаажуулах захидлаар Шарын гол ХК-ийн үлдэгдэл 615,556.6 мянган төгрөгийн авлагатай гэж ирүүлсэн. 2 байгууллагын маргаантай асуудал аудитын явцад эвлэрэхээр шүүхээс нэхэмжлэлээ татсан, дахин тооцоо нийлэх ажил хийгдэж байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Тус байгууллагын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

“Дулаан Шарын Гол” ТӨХК-ийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 5,522,728.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснийг Менежментийн захидлаар нэгтгэн үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэн тайлбар, нотолгоог авч дүгнэлээ.

Мөнгөн дүнгээр залруулга хийх 753,540.1 мянган төгрөгийн 4 асуудлаас залруулахаас татгалзсан НББОУС хэрэгжүүлээгүй 1 асуудал 200,000.0 мянган төгрөгийг зөрчил гэж үзсэн. Ашиглалтын хугацаа дуусаагүй 4,085.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлгүйгээр данснаас хассан зөрчил байна.

Мөнгөн дүнгээр залруулагдахгүй боловч үйл ажиллагааны үр дүнд засаж сайжруулахаар хүлээн зөвшөөрсөн тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй тайлагнасан 78,872.2 мянган төгрөгийн борлуулалтын авлага, анхан шатны баримт, нягтлан бодох бүртгэлээр нотлогдохгүй байгаа 17,502.9 мянган төгрөгийн зөрчил байна.

ХЭ-ийн хурлаар шийдвэрлүүлэхээр хүлээж байгаа найдваргүй авлага 7,400.8 мянган төгрөг, эвлэрэхээр шүүхээс татсан 542,054.2 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан өрийг дараагийн тайлангийн хугацаанд залруулж болно гэж үзсэн.

Мөн жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг хийж гүйцэтгэсэн боловч дүрэм, журмын дагуу бүртгэл тооцоог гаргаж бүрэн нэгтгээгүй 3,386,893.8 мянган төгрөг, нэмэгдэл орлого олсонтой холбоотой гарсан зарим зардлын төрлөөр батлагдсан төлөвлөгөөнөөс хэтрүүлэн зарцуулсан 37,763.7 мянган төгрөгийг ТУЗ-д танилцуулан тодотгол хийлгээгүй зөрчлийг менежментийн захидлаар зөвлөмж өгч, тайлбар авч хавсаргалаа.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

“Дулаан Шарын Гол” ТӨХК-ийн 2015 оны санхүүгийн тайланд “Ди Эй Би Жи Аудит” ХХК-ийн хийсэн аудитаар 4 асуудлаар зөвлөмж өгснийг тайлант хугацаанд 1 асуудлыг бүрэн хэрэгжүүлж, 2 асуудлыг хэрэгжүүлж эхэлсэн, 1 асуудал хэрэгжээгүй байгаа тул 50 хувь биелүүлсэн гэж дүгнэсэн. Дараах хэрэгжээгүй асуудлууд нь аудитын хугацаанд шийдэгдээгүй байна.

- 1) Олон жил болсон айл өрхүүдийн 1 жилээс дээш насжилттай авлагыг барагдуулах. Цаашид борлуулагч нарын ажлын гүйцэтгэлд сар тутам хяналт тавих, авлагыг баталгаажуулах зөвлөмжийн дагуу авлаг баталгаажуулах ажил хийгдэж эхэлсэн боловч аудитын хугацаанд 60 хувийн гүйцэтгэлтэй байна.

- 2) Олон жил шийдэгдээгүй 2 байгууллагын томоохон өрийн асуудлыг шийдвэрлүүлэхээр шүүхийн байгууллагад хандаж, 200.0 сая төгрөгийн өр төлөхөөр шийдвэр гарсан. Нүүрсний үнийн зөрүүгээс үүссэн дээд газрын шийдвэртэй Шарын гол ХК-ийн өрийг хэлэлцэж байгаа боловч бүрэн шийдвэрлэгдээгүй байна.
- 3) Шарын гол ХК-иас авсан нүүрсний НӨАТ-ын падааныг авч байгаагүйгээс өмнөх жилүүдэд НӨАТ-ын тайланд орлогоо бууруулан тайлагнаж байсныг залруулах зөвлөмж хэрэгжээгүйгээс татварын алданги төлсөн байна.

Тайлбар захидал

АОУСтандарт 580-ын дагуу үйлчлүүлэгчийн удирдлагаас бид энэхүү санхүүгийн тайланг стандарт, хууль журамд нийцүүлэн бэлтгэсэн талаарх хариуцлагыг хүлээх болон гаргаж өгсөн баримт нотолгоонууд бүрэн гүйцэд үнэн зөв гэдгийг баталсан удирдлагын хариуцлагын захидлыг 2017.03.09-ний өдөр албан бичгээр гаргуулан авч хавсаргалаа.

Хязгаарлалттай санал дүгнэлт

“Дулаан Шарын Гол” ТӨХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлангийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг дээр дурьдсан зөрчлийн үзүүлж болзошгүй нөлөөллийг эс тооцвол НББОУС, СТОУС, Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу илэрхийлсэн байна.

ЭХЯ-НЫ ХАРЪЯА “ДУЛААН ШАРЫН ГОЛ” ТӨХК 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 1	
Борлуулалтын авлагын бүртгэл.....	2
Асуудал 2	
Бусад авлагын бүртгэл.....	3
Асуудал 3	
Өр төлбөрийн бүртгэл.....	4

Тэргүүлэх ач холбогдол №3 зүйлс:

Асуудал 4	
Өр төлбөрийн бүртгэл.....	5
Асуудал 5	
Хөрөнгийн тооллого.....	6
Асуудал 6	
Худалдан авалт.....	7
Асуудал 7	
Хөрөнгийн ашиглалт.....	8
Асуудал 8	
Төрийн өмчийн бүртгэл.....	9
Асуудал 8	
Төлөвлөгөөт зорилт.....	10

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг “Дулаан Шарын Гол” ТӨХК-ий удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал буюу горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулж болох зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ҮАГ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан “Дулаан Шарын Гол” ТӨХК-ий удирдлага болон ажилтнуудад талархал илэрхийлье.

Ажиглалт

Борлуулалтаас үүссэн авлагын дүнд айл өрхүүдийн 69,645.1 мянган төгрөг, албан байгууллагын 9,227.1 мянган төгрөг нийт 78,872.2 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй тайлагнасан нь НББ-ийн тухай хуулийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэснийг хэрэгжүүлээгүй байна.

Эрсдэл

НББ-ийн бодлогодоо бусад хууль, журмаар тооцдог хөөн хэлэлцэх хугацааг авлагын насжилтаар ангилах хугацаанд тусган баримтлаагүй, цаг алдалгүй холбогдох ажилтан, алба нэгж хөөцөлдөж барагдуулаагүйгээс найдваргүй өр авлага үүсэх, ихээхэн хэмжээний алдагдал хүлээх эрсдэлтэй

Зөвлөмж

Тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй авлагын бодитой төлөгдөх болон нийт авлагаас найдваргүй болох магадлалтай дүнг гаргаж ирүүлэх. Удирдлага, дотоод хяналтын зүгээс холбогдох хуулиудын дагуу хэрэг хөөн хэлэлцэх хугацаа зэргийг харгалзан хууль хяналтын байгууллагад шилжүүлэх нэхэмжлэлүүдийг цаг алдалгүй шийдвэрлэж байх

Үйлчлүүлэгчийн хариу

БА бууруулах талаар өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу тодорхой ажил зохион байгуулж, ажилласны үр дүнд 2016 онд айл өрхийн авлага 25.1 сая төгрөгөөр буурсан. Авлагын үлдэгдлийг баталгаажуулах ажил 2017.01.16-наас сарын хугацаатай ажил зохион байгуулж, 60 хувийн биелэлттэй байна. Баталгаажилтын явцад цаашид найдваргүй болох магадлалтай өндөр дүнтэй 69 өрхийн 46.3 сая төгрөгийн авлагыг хууль хяналтын байгууллагад өгч шийдвэрлүүлэхээр материалыг бүрдүүлж байна. ААНБ-ын 9.2 сая төгрөгийн авлагыг баталгаажуулаагүй нь эзэн холбогдогч байхгүй, холбоо барих боломжгүй, түрээсээр ажиллуулж байгаа гэсэн шалтгаантай мөн хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэхээр материал бүрдүүлж байна.

Ажиглалт

2 харилцагчийн 12,137.7 мянган төгрөгийн авлага тайлант жилийн төгсгөлд шүүхийн ажиллагаа явагдаж байсан бөгөөд балансын дараа аудит хийгдэх хугацаанд "АНУ Капитал" ХХК-ийн авлага 7,400.7 мянган төгрөгийг Дархан-уул аймгийн ИХАШ-ны шүүхийн 2017.02.03-ны өдрийн 177-р шийдвэрээр төлбөрийн чадваргүйн улмаас хэрэгсэхгүй болсон байна.

Зөвлөмж

Тайлагналын дараа үеийн үйл явдал НББОУС 10.8-ын дагуу шүүхийн шийдвэрийг үндэслэн 7,400.7 мянган төгрөгийн авлагыг, Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт НББОУС 8.36.а-ын дагуу авлага бууруулан, алдагдлаар хүлээн зөвшөөрч, залруулан бүртгэх

Эрсдэл

Маргаантай өр төлбөрийг цаг хугацаа алдахгүй шийдвэрлүүлээгүйгээс хууль хяналтын байгууллагаас сөрөг шийдвэр хүлээн авч материаллаг хэмжээний алдагдал хүлээх эрсдэлтэй

Үйлчлүүлэгчийн хариу

Дархан-Уул аймгийн ИХАШ-ийн 2017.02.03-ны өдрийн 177 тоот шийдвэрээр хэрэгсэхгүй болгосон 7,400.7 мянган төгрөгийн авлагыг 2017 оны 1 дүгээр улиралд багтаан холбогдох эрх бүхий байгууллагад танилцуулан авлага бууруулан алдагдлаар залруулан тайлагнана.

Ажиглалт

Аудитын тулган баталгаажуулах захидлаар Дансны өглөг дансанд Шарын гол ХК-ийн үлдэгдэл 542,054.3 мянган төгрөг, Дансны өглөг-Ашиглалтын зардал дансанд ДСЦТС ХК-ийн үлдэгдэл 200,000.0 мянган төгрөг нийт 742,054.3 мянган төгрөгийг санхүүгийн тайланд дутуу, зөрүүтэй тайлагнасан нь батлагдсан. Дархан-уул аймгийн анхан шатны шүүхийн 2016.01.19-ний 644, 2016.08.25-ны 1124-р шийдвэрүүд нь харилцагч 2 байгууллагын талд гарсан байна. Дээд шүүхийн ХШИХ-ийн 2017.01.24-ний өдрийн 001/2017/00072-р тогтоол нь ДСЦЭС ХК-ийн анхан шатны шүүхийн шийдвэр зөв болохыг баталж, Дулаан шарын гол ТӨХК нь 200,000.0 мянган төгрөгийг нэмж төлөхөөр тогтоосны дагуу залруулан бүртгээгүй нь НББ-ийн тухай хуулийн 20.2.6. "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"; 5.1.4. Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: "үнэн зөв байх" гэснийг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Эрсдэл

Маргаантай өр төлбөрийг нотлох баримт материалд үндэслэн үнэн зөв бүртгээгүй, цаг хугацаа алдахгүй шийдвэрлүүлээгүйгээс хууль хяналтын байгууллагаас сөрөг шийдвэр хүлээн авч материаллаг хэмжээний алдагдал хүлээх, үргүй зардал гарах эрсдэлтэй

Зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн алдаа НББОУС 8.42-ын дагуу "ДСЦТС" ХК-ийн өглөгийг 200,000 мянган төгрөгийг өр төлбөр, өмнөх үеийн алдагдлыг нэмэгдүүлэн залруулан тайлагнах. ШГХК-ийн зөрүүтэй тооцоог баталгаажсаны дараа НББ-ийн тухай хуулийн 5.1.4 "үнэн зөв байх" зарчмыг баримтлан дараагийн тайлант хугацаанд залруулан тайлагнах

Үйлчлүүлэгчийн хариу

Шарын гол ХК-ийн үлдэгдлийн зөрүү нь 2014-2015 онуудын нүүрсний үнэ тохиролцоогүйгээс үүссэн бөгөөд ШГХК нь тохиролцохоор давах шатны шүүхээс өргөдлөө буцаан авч 2017.02 сард 2016.12.31-ний байдлаар тооцоо нийлэхэд 83,048.2 мянган төгрөгийн өглөгтэйгээр урьдчилан тооцоо гарсан бөгөөд тэдний зүгээс эцэслэн шийдвэр гаргаагүй байгаа болно.

ДСЦТС ХК-ийн өглөгийг залруулаагүй байгаа нь 2016 оны эцсийн санхүүгийн тайлант хугацаа тухайн оны 2016.12.31-ээр тасалбар болдог бөгөөд давж заалдах дээд шатны шүүх хурал 2017.01.21-нд болж, 2017.02.22-нд шийдвэр ирсэн тул 2017 ондоо залруулах болно.

Ажиглалт

Дансны өглөг дансанд 3-аас дээш жилийн насжилттай, үндсэн баримт санхүүгийн бүртгэлээр нотлогдохгүй байгаа 6 байгууллагын 17,502.9 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй тайлагнасан нь НББ-ийн тухай хуулийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", 11.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн баримт болон санхүүгийн тайланг Архивын тухай хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол 10-аас доошгүй жил хадгална" гэснийг хэрэгжүүлээгүй байна

Эрсдэл

Өр төлбөрийг үүссэн цаг хугацаанд нь тооцоо нийлсэн актаар баталгаажуулан тайлагнах, төлөх үүрэг хариуцлагаа биелүүлж байгаагүйгээс материаллаг хэмжээний хөрөнгө завшигдах, алданги торгууль хүлээх, үргүй зардал гарах эрсдэлтэй

Зөвлөмж

Олон жилийн насжилттай 6 байгууллагын 17,502.9 мянган төгрөгийн өр төлбөрийн тооцоог үүссэн хугацааны хариуцах ажилтнуудаас лавлагаа авах, санхүүгийн баримт бүртгэлийг гаргаж дотоод хяналт, өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт шийдвэрүүдийг хавсарган ирүүлэх.

Үйлчлүүлэгчийн хариу

Дархан МХГ болон Интерпресс ХХК-ийн нэхэмжилсэн үнийн дүн зөрүүтэй байгаа бөгөөд одоогоор тооцоо нийлэн үлдэгдлээ баталгаажуулаагүй. Цаашид тооцоо барагдуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Ажиглалт

Санхүүгийн тайлангаар 3,252,596.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 121,981.6 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгө тайлагнасан. Жилийн эцсийн үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тооллого хийх тухай захирлын 2016 оны А/35 тушаал гарч тооллогын комиссын бүрэлдэхүүн, тооллого хийх хуваарийг баталсан байна. Аудитын багт тооллогын бүртгэл, тооллогын үр дүнг нэгтгэсэн бүртгэл, тайланг ирүүлээгүй нь НББ-ийн тухай хуулийн 12.1. "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2. "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: 12.2.1. жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" гэснийг хэрэгжүүлээгүй байна.

Эрсдэл

Хөрөнгийн тооллого хийж тооцоо бодох үйл явцад зохих хууль, журмыг баримтлаагүй, Захирлын тушаалын дагуу тооллого хийгээгүй, үр дүнг хэлэлцүүлээгүйгээс хөрөнгө эзэнгүйдэх, завшигдах эрсдэл үүсэх

Зөвлөмж

ТБОНӨ-ийн тухай хуулийн 72, 73-р зүйлүүдийг мөрдөн тооллогыг явуулж үр дүнг тодорхойлж хэвших. Захирлын тушаалын хэрэгжилтийг дүгнэсэн албан ёсны баримт бичиг, дотоод хяналт, өмч хамгаалах байнгын зөвлөлийн албан ёсны тогтоол, шийдвэрүүдийг ирүүлэх. Яамны дотоод хяналтаар тогтоосон ашиглах боломжгүй 10 нэр төрлийн 38.4 сая төгрөгийн хөрөнгийг ТБОНӨ-ийн тухай хуулийн 16, 31-д нийцүүлэн худалдан борлуулж компанийн төлбөр тооцоог сайжруулах ажил хэрэгжүүлэх

Үйлчлүүлэгчийн хариу

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Ажиглалт

Батлагдсан төлөвлөгөөний дагуу нийт 293,566.6 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн. Үүнээс бусад сэлбэг 834.0 мянган төгрөг, тавилга эд хогшил 2,644.0 мянган төгрөг, компьютер дагалдах хэрэгсэл 5,818.7 мянган төгрөг нийт 9,296.7 мянган төгрөгийн худалдан авалт нь батлагдсан төсвийг хэтрүүлсэн нь ТБОНӨ-ийн тухай хуулийн 11.3 "төрийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалтыг холбогдох байгууллагатай тохиролцон тогтоох"; 14.2.1 "өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах" гэснийг хэрэгжүүлээгүй байна

Эрсдэл

Батлагдсан төсөв, худалдан авалтын тухай хуулийг баримтлаагүйгээс ажилтнуудад ашиг сонирхлын зөрчил үүсэх, илүүдэлтэй хөрөнгө бэлтгэх, үргүй зардал гарах эрсдэлтэй байна.

Зөвлөмж

ТБОНӨ-ийн тухай хуулийн 20.3-д "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэснийг хэрэгжүүлэх. Баталсан төсвийг хэтрүүлэн зарцуулсан тайлбар, хэрэв холбогдох зөвшөөрөл байгаа бол тайлбарын хамт ирүүлэх

Үйлчлүүлэгчийн хариу

ШГХК-ийн зарим хэсэг халаалт нэмж авсантай холбоотойгоор 140,41.8 мянган төгрөгийн орлого орсон ба нүүрс, цахилгаан болон засварын зардал нэмж гарсан. Бусад зардлаар тайлагнасан төлөвлөгөөнд ороогүй НӨАТ-ын татвар ногдолтын алданги 8,861.6 мянган төгрөг, шүүхийн шийдвэр гарч найдваргүй болох нь тогтоогдсон 2,227.7 мянган төгрөгийн авлагыг ХЭХ-ын тогтоолоор найдваргүй авлагаар бүртгэхийг зөвшөөрсөн зардлууд болно.

Ажиглалт

4-р зууханд их засвар хийхдээ хуучин зуухнаас 4,085.0 мянган төгрөгийн сэлбэгийг ямар нэг тогтоол шийдвэргүй зарцуулсан нь ТБОНӨ-ийн тухай хуулийн 16.2. "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар үндсэн хөрөнгийг зөвхөн төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлтэйгээр данснаас хасах буюу борлуулах, устгах эрхтэй" гэснийг хэрэгжүүлээгүй

Зөвлөмж

ТБОНӨ-ийн тухай хуулийн 31.3.1-д "худалдах, шилжүүлэх, устгах эд хөрөнгийн талаар өмч хамгаалах Байнгын зөвлөл дүгнэлт гаргасан байх" гэснийг хэрэгжүүлж дээрх хөрөнгийг сэлбэгээр зарцуулах шийдвэрийг ирүүлэх

Эрсдэл

Хөрөнгийн ашиглалтад тавих хяналтыг сулруулснаар хөрөнгө завших, хөрөнгийг үнэгүйдүүлэх эрсдэлтэй

Үйлчлүүлэгчийн хариу

К4 зуухны засварт шаардлагатай болсон ул ширэмний хөтлөгч 200ш, колосник 450ш-г Хятад улсаас захиалж авахад хугацаа оройтсон таарах сэлбэг олдоц муу байсан учир засварын ажлыг цаг алдалгүй, яаралтай хийх шаардлагын улмаас Техникийн комиссын дүгнэлт гарсан учир хөрөнгө хооронд шилжүүлэн зарцуулж бүртгэсэн.

Ажиглалт

Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг данснаас төрийн өмчийн дансанд ХЭ-ийн хурлын 2016 оны 07 тогтоолын дагуу 491,377.5 мянган төгрөгийг шилжүүлэн бүртгэсэн байна. Дээрх бүртгэл нь тогтоолын хавсралтын дүнтэй 1.0 сая төгрөгийн зөрүүтэй. Мөн хурлын тогтоолоор УБЕГ, СЗХ, МХБ-д бүртгүүлэн зохих зөвшөөрөл шийдвэрүүд гараагүй байхад бүртгэсэн нь Компанийн тухай хуулийн 17.4-д "Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг тухайн шийдвэр гарснаас хойш ажлын 10 өдрийн дотор хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлнэ" гэснийг хэрэгжүүлээгүй байна.

Эрсдэл

Өмчийн өөрчлөлтийг хууль, журмын дагуу хийж, бүртгүүлээгүй, хянаагүйгээс компанийн өмч завших, үнэгүйдэх эрсдэлтэй

Зөвлөмж

ТБОНӨ-ийн тухай хуулийн 21.6. "Төрийн өмчийн төлөөлөгч болон төлөөлөн удирдах зөвлөлийн төрийг төлөөлөх гишүүнээр томилогдсон этгээд нь төрийн мэдлийн хувьцаа эзэмшигчээс баталсан удирдамж, зааврыг баримтлан ажиллана. Удирдамж, зааврыг зөрчсөн буюу зохих ёсоор биелүүлээгүй нь түүнийг томилсон шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болно" гэснийг хэрэгжүүлж тогтоолын хавсралтыг засуулах, холбогдох байгууллагуудад бүртгүүлэх ажлыг хууль журмын дагуу гүйцэтгэж, өмчийн өөрчлөлтийг тайлагнах

Үйлчлүүлэгчийн хариу

ХЭХ-ын тогтоолын хавсралтын дүн 1.0 сая төгрөгийн зөрүүтэй гарсан байсныг холбогдох байгууллагад мэдэгдэхэд зөрүүг дараагийн хурлаар шийдвэрлүүл гэсэн хариу өгсөн. 2017 онд залруулга хийлгэж, тогтоол гаргуулан бүртгүүлнэ.

Ажиглалт

Батлагдсан төлөвлөгөөнөөс цалин, нийгмийн даатгалын зардлыг 25,056.7 мянган төгрөгөөр хэмнэж, урсгал засварын зардлыг 6,629.5 мянган төгрөг, нүүрсний зардал 20,096.9 мянган төгрөг, бусад зардал 11,037.3 мянган төгрөгөөр хэтрүүлсэн нь материаллаг байдлыг агуулж байна. Зардлыг батлагдсан төлөвлөгөөнөөс нийт дүнгээр 8,061.2 мянган төгрөгөөр хэтрүүлсэн нь ТБОНӨ-ийн тухай хуулийн 20.3-д "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэснийг хэрэгжүүлээгүй

Эрсдэл

Батлагдсан төсвийг дагаж мөрдөөгүй, Төсвийн болон ТБОНӨ-ийн тухай хуулийг баримтлаагүйгээс үргүй зардал гарах эрсдэлтэй байна

Зөвлөмж

Баталсан төсвийг хэтрүүлэн зарцуулсан тайлбар, хэрэв холбогдох зөвшөөрөл байгаа бол тайлбарын хамт ирүүлэх, Цаашид Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарчмуудыг баримталж ажиллах

Үйлчлүүлэгчийн хариу

Холбогдох баримт материалыг хүргүүлсэн. Цаашид Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарчмуудыг баримталж ажиллана.

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

"Дулаан Шарын гол" ТӨХК

2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ		
1.1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		
1.1.1	Мөнгөн түүнтэй адилтгах хөрөнгө	1,762,762.63	29,888,922.12
1.1.2	Дансны авлага	286,868,878.02	183,837,902.68
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага		
1.1.4	Бусад авлага	19,746,447.20	17,842,819.74
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	168,290,985.72	121,981,643.83
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		8,760,000.00
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй ЭБХ		
1.1.20	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	476,669,073.57	362,311,288.37
1.2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,425,707,691.73	1,434,722,848.77
1.2.2	Биет бус хөрөнгө	10,989,635.08	11,045,925.36
1.2.3	Биологийн хөрөнгө	3,230,000.00	3,230,000.00
1.2.20	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,439,927,326.81	1,448,998,774.13
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,916,596,400.38	1,811,310,062.50
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	842,327,517.30	720,613,050.47
2.1.1.2	Цалингийн өглөг	26,639,310.12	
2.1.1.3	Татварын өр	96,677,667.07	134,984,297.66
2.1.1.4	НДШ-ийн өглөг	65,249,475.00	57,922,946.78
2.1.1.20	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,030,893,969.49	913,520,294.91
	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	1,030,893,969.49	913,520,294.91
2.3	ЭЗДИЙН ӨМЧ		
2.3.1	Төрийн өмч	1,781,336,311.04	2,272,713,862.35
2.3.2	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	12,160,756.82	12,160,756.82
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	1,979,229,804.67	1,487,852,253.36
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(2,887,024,441.64)	(2,874,937,104.94)
2.3.20	ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	885,702,430.89	897,789,767.59
	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,916,596,400.38	1,811,310,062.50

Гүйцэтгэх захирал:/Б.Энхцэцэг/

Нягтлан бодогч:/Ж.Даш/

Баталгаажуулсан:

АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

"Дулаан Шарын гол" ТӨХК "

2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Борлуулалтын орлого	2,101,022,800.16	2,453,087,735.12
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	2,038,783,117.70	2,397,674,705.06
3	Нийт ашиг, алдагдал	62,239,682.46	55,413,030.06
4	Түрээсийн орлого		
5	Хүүгийн орлого	1,200,774.69	
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	54,855,332.13	74,520,040.97
9	Ерөнхий ба удирдлагын зардал	54,667,821.07	54,954,898.68
10	ТУЗ-ийн зардал	32,764,029.45	35,259,352.42
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	41,644,947.16	43,523,486.21
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз, гарз	(266,045.00)	
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз, гарз		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз, гарз		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз, гарз		
17	Бусад ашиг, алдагдал		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг, алдагдал	(11,047,053.40)	(3,804,666.28)
19	Орлогын татварын зардал	120,077.46	
20	Татварын дараах ашиг, алдагдал	(11,167,130.86)	(3,804,666.28)
21	Зогсоосон үйл ажиллагааны дараах ашиг, алдагдал		
22	Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	(11,167,130.86)	(3,804,666.28)
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
24	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
25	Гадаад валютын ххөрвүүлэлтийн зөрүү		
26	Бусад олз, гарз		
27	Орлогын нийт дүн	(11,167,130.86)	(3,804,666.28)
28	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг, алдагдал		

Гүйцэтгэх захирал:/Б.Энхцэцэг/

Нягтлан бодогч:/Ж.Даш/

Баталгаажуулсан:

АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

"Дулаан Шарын гол" ТӨХК

2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар

төгрөг

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2014 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,781,336,311.04	12,160,756.82	1,979,229,804.67	(2,875,976,726.24)	896,750,146.29
2	НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
3	Залруулсан үлдэгдэл	1,781,336,311.04	12,160,756.82	1,979,229,804.67	(2,875,976,726.24)	896,750,146.29
4	Тайлант үеийн цэвэр ашиг/алдагдал				(11,047,053.40)	(11,047,053.40)
5	Бусад дэлгэрэнгүй орлого					-
6	Өмчид гарсан өөрчлөлт					-
7	Зарласан ноогдол ашиг					-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
9	2015 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,781,336,311.04	12,160,756.82	1,979,229,804.67	(2,887,023,779.64)	885,703,092.89
10	НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				15,891,340.98	15,891,340.98
11	Залруулсан үлдэгдэл	1,781,336,311.04	12,160,756.82	1,979,229,804.67	(2,871,132,438.66)	901,594,433.87
12	Тайлант үеийн цэвэр ашиг/алдагдал				(3,804,666.28)	(3,804,666.28)
13	Бусад дэлгэрэнгүй орлого					-
14	Өмчид гарсан өөрчлөлт	491,377,551.31		(491,377,551.31)		-
15	Зарласан ноогдол ашиг					-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
17	2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,272,713,862.35	12,160,756.82	1,487,852,253.36	(2,874,937,104.94)	897,789,767.59

Гүйцэтгэх захирал

/Б.Энхцэцэг/

Нягтлан бодогч:

/Ж.Даш/

Баталгаажуулсан:



АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

УТ-4А

"Дулаан Шарын Гол" ТӨХК

2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх жилийн дүн	Тайлант үеийн дүн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн	1,696,310,949.88	1,987,439,563.88
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,194,927,559.88	1,483,518,243.13
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
	Буцаан авсан албан татвар		321,335.45
	Татаас санхүүжилтийн орлого	500,000,000.00	500,000,000.00
	Бусад мөнгөн орлого	1,383,390.00	3,599,985.30
1.2	Мөнгөн зарлагын дүн	1,698,152,617.19	1,875,936,314.56
	Ажиллагчдад төлсөн	622,283,575.76	739,886,296.01
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	192,720,000.00	196,828,091.19
	Бараа материал худалдан авахад төлсөн	542,040,225.97	421,438,252.19
	Ашиглалтын зардалд төлсөн	251,535,173.00	340,750,000.00
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	14,025,000.00	41,058,806.22
	Хүүний төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн	59,323,653.13	123,765,756.90
	Даатгалын төлбөрт төлсөн	674,274.00	
	Бусад мөнгөн зарлага	15,550,715.33	12,209,112.05
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,841,667.31)	111,503,249.32
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн	1,200,774.69	-
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
	Хүлээн авсан хүүний орлого	1,200,774.69	
	Хүлээн авсан ноогдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн	-	83,377,089.83
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		83,377,089.83
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,200,774.69	(83,377,089.83)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн	-	-
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
	Валютын ханшийн зөрүү		
3.2	Мөнгөн зарлагын дүн	-	-
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Валютын ханшийн зөрүү		

3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(640,892.62)	28,126,159.49
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,403,655.25	1,762,762.63
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,762,762.63	29,888,922.12

Гүйцэтгэх захирал:/Б.Энхцэцэг/

Нягтлан бодогч:/Ж.Даш/

Баталгаажуулсан: